



## ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГЫН НОГООН АЛТ ТӨСӨЛ

### БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ “ЭРҮҮЛ БЭЛЧЭЭР-ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” СЭДЭВТ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

#### Уралдааны зорилго:

❖ Бэлчээрийн менежментийг малчдын бэлчээр ашиглах уламжлалт эрхийг баталгаажуулах, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, бэлчээрийг экологийн чадавхи, сэргэх чадварт үндэслэн сайжруулах;

❖ Бэлчээрийн менежментийн сайн туршлагуудыг сурталчлах, дэмжих, байгууллага мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, малчдын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг тогтмолжуулах, чанарыг сайжруулах явдлыг дэмжин дэлгэрүүлэхэд энэхүү уралдааны зорилго оршино.

**Уралдааныг бүх аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын байгууллагын дунд өрнүүлэн зохион байгуулна. Уралдаанд оролцогчид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.**

#### Нэг. Уралдааны үзүүлэлт

❖ Бэлчээр ашиглагчдын хэсэг (бүлэг, нөхөрлөл) нь зохион байгуулалтанд орсон, бэлчээр ашиглах гэрээ байгуулсан, гэрээнд малчин өрхийн мэдээлэл, гэрээг бэлчээрийн хэмжээ байршил, улирлын хуваарийн зураг, бэлчээрийн газрын экологийн чадавхийн зураглал, бэлчээрийн төлөв байдал, шилжилтийн засвар, фотомониторингийн аргаар үнэлсэн суурь мэдээллийг бүрэн тусгасан байх, гэрээний хүрээнд бэлчээр сайжруулах, хөрөнгө оруулалт татах болон бусад

чиглэлээр хамтран тодорхой ажил хийж үр дүн гаргаж сайн туршлага хуримтлуулсан байх;

❖ Сумын Засаг даргын Тамгын газар нь Сумын бэлчээрийн менежментийн ажлы хэсгийг талуудын оролцоог ханган байгуулж үйл ажиллагааг нь дэмжсэн байх, ажлын хэсэг нь Бэлчээр ашиглагчдын хэсэг (бүлэг, нөхөрлөл)-тэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулж дүгнэсэн байх, фотомониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бэлчээр ашиглах журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрсдлийн сан байгуулах, МАА-н үйлдвэрлэл болон бэлчээрийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа, сургалт, мэдээллийн ажлын цар хүрээ, чанарыг нэмэгдүүлэх талаар тэргүүн туршлага нэвтрүүлсэн байх;

❖ Аймаг, сумын бэлчээр ашиглагчдын холбоо нь Бэлчээр ашиглагчдын хэсэг (бүлэг, нөхөрлөл)-үүдийг бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах, бэлчээр ашиглалтын журам, төлөвлөгөө, фотомониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байх, малчдын байгууллагын зохистой бүтэц, санхүү, дундын сангийн үр ашигтай менежментийг нэвтрүүлэх, малчдын байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах талаархи сайн туршлага нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулсан байх;

❖ Аймгийн бэлчээрийн менежментийн ажлын хэсэг нь Бэлчээр ашиглах гэрээг орон нутагт нэвтрүүлэх, сургалт мэдээллийг малчдад хүргэх, талуудын оролцоог хангах, фотомониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бэлчээр ашиглах журам, төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, сум, аймгийн хэмжээнд бэлчээр ашиглалтын нөлөө, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр найдвартай хангах, хэрэглээнд оруулах талаар тодорхой үр дүн гаргасан байх;

❖ Байгууллага, мэргэжилтэн, баг хамт олон нь малчид, малчдын байгууллагыг хөгжүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, МАА-н үйлдвэрлэл, нэг малаас болон бэлчээрийн нэгж талбайгаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, бэлчээрийн менежмент, хяналт үнэлгээг малчдын оролцоотойгоор зохион байгуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар нийтэд түгээн дэлгэрүүлэхүйц сайн туршлагыг нэвтрүүлсэн байх.

## **Хоёр. Уралдааныг дүгнэх, шагнаж урамшуулах байдал**

Энэхүү уралдаан нь 2016 оны 6 дугаар сарын 1-ээс 12 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл явагдах бөгөөд болзлын үзүүлэлтийг хангасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, баг, хамт олон нь өөрийн харъяалах сумын бэлчээр ашиглагчдын холбоо (ЗДТГ), аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо (АЗДТГ)-оор уламжлуулан Ногоон-Алт төсөлд хандаж уралдааны шалгаруулалтанд оролцоно.

Уралдааны шалгаруулалтанд оролцогчид ажлын танилцуулга, бусад материалаа оролцохыг хүссэн номинаци бүрээр бэлтгэж 2016 оны 12 дугаар сарын 1-нээс 05-ны хооронд төсөл өгсөн байна. Уралдааны шалгаруулалтанд 12 дугаар сарын 05-аас 10-ний өдрүүдэд явагдана. Шилдэг туршлага бүхий оролцогчдыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилна.

Уралдаанд шалгарсан шилдэг туршлага бүхий үлгэр жишээ оролцогчдыг доорх номинациар шалгаруулж шагнаж урамшуулна.

Шагналын нийт сан 40,0 сая төгрөг болно.

Үүнд:

❖ “Бэлчээрийн шилдэг менежмент бүхий үлгэр жишээ БАХ” номинацид 80 хүртэл Бэлчээр ашиглагчдын хэсгийг шалгаруулж шилдэг БАХ-ийн шагналын сан 20,0 сая төгрөгөөс шагнаж урамшуулна;

❖ “Бэлчээрийн шилдэг менежменттэй сум” номинацид 10 хүртэл сум (ЗДТГ, СБАХ)-ыг шалгаруулж шилдэг сумын шагналын сан 5,0 сая төгрөгөөс шагнаж урамшуулна;

❖ “Бэлчээрийн шилдэг менежменттэй аймаг” номинацид 3 хүртэл аймаг (ЗДТГ, АБАХ, албад)-ыг шалгаруулж шилдэг аймгийн шагналын сан 5,0 сая төгрөгөөс шагнаж урамшуулна;

❖ “Бэлчээрийн менежментийг чадварлаг зохион байгуулсан “Шилдэг менежер, шилдэг мэргэжилтэн” номинацид 10 хүртэл оролцогчийг шалгаруулж шилдэг менежер, мэргэжилтний шагналын сан 5,0 сая төгрөгөөс шагнаж урамшуулна;

❖ Фотомониторингийн хөтөлбөрийг үлгэр жишээ хэрэгжүүлсэн “Шилдэг туршлага бүхий байгууллага, баг хамт олон” номинацид 10 хүртэл оролцогчийг шалгаруулж шилдэг оролцогчийн шагналын сан 5,0 сая төгрөгөөс шагнаж урамшуулна.

*Хамтран санхүүжүүлж байгаа байгууллагууд*

- Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Архангай аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Баян-Өлгий аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Баянхонгор аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Говь-Алтай аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Ховд аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Увс аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Завхан аймгийн бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо